Үенч сумын засаг дарга нь Монгол улсын Үндсэн хууль болон УИХ, Засгийн газраас гарч буй хууль тогтоомжид нийцүүлэн төрийн үйлчилгээг ард иргэдэд чанартай ил тод, тэгш хүргэж ажилгүйдэл, ядуурлыг бууруулан, хувь хүмүүс өрх гэрүүдэд өөрийгөө тэтгэн хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, тэдний бие бялдар, сэтгэл зүйн сайн сайхан байдлыг хамгаалах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд сумынхаа эдийн засаг, нийгмийн хөгжлийг эрчимжүүлж, байгаль орчин, бизнест ээлтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлэх
- Төрийн үйлчилгээг чанарын шинэ шатанд гаргаж, ард иргэдийнхээ амьдрах орчныг сайжруулах, аж амьдралыг дээшлүүлэх олон талт үйл ажиллагаа явуулах

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Үенч сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Ховд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүү, дотоод аудитын албанаас 2020 онд Үенч сумын ТТЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд 2018-2019 онуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж орон нутгийн төсөвт оруулахаар 8143.1, сумын төсөвт оруулахаар 4217.3 мянган төгрөгийн төлбөрийн акт бичигдсэн байна.

Үенч сумын ТТЗ-ын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшнийг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Энэ нь материаллаг байдлыг үнэ цэнэ талаас нь авч үзэхийн тулд санхүүгийн тайлангийн хамгийн чухал хэсгүүд болох нийт орлогыг /өөрийн орлого, төсвийн санхүүжилт, татвар болон татварын бус орлог/-ыг сонгон авч үзлээ.

Төлөвлөлтийн үе шатанд 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангаас тооцсон бол гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн нийт орлогын 3769871.1 мянган төгрөгөөс 1 хувиар тооцож 37698.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 118093.2 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 148914.8 мянган төгрөг болж 30821.6 мянган төгрөгөөр буюу 26.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1: Мөнгөн хөрөнгө

мянган төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Үенч МУБ ОНӨААТҮГ		143.7	143.7	0.1
Үенч Эрчим хүч ТӨААН	166.9	166.9	0	0.1
ОНХС	5458.1	46288.7	40830.6	31.0
СХС	1763.4	2854.1	1090.7	1.9
Төрийн сан	110871.7	99628.3	-11243.4	66.8
Дүн	118260.1	149081.7	30821.6	100

Эх сурвалж: Үенч сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 148914.8 мянган төгрөгөөс 148771.1 мянган төгрөг нь төрийн сангийн харилцах дансанд, 143.7 мянган төгрөг нь арилжааны банкны харилцах дансанд, 166.9 мянган төгрөг нь кассад байгаа мөнгөн хөрөнгө байна.

3.5.2 Авлага

Авлага ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.~~ дансны эхний үлдэгдэл 319468.9 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 258636.5 мянган төгрөг болж 60832.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2: Авлагын үлдэгдэл

мянган төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	46,385.0	10,530.8	(35,854.2)
Байгууллагаас авах авлага	25,588.4	986.8	(24,601.6)
Хувь хүмүүсээс авах авлага	6,292.2	6,292.2	-
Зээлийн хүүгийн авлага			-
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага			-
Дансны авлага /ОНӨААТҮГ/	8,542.0	8,542.0	-
Зээлийн авлага	230,952.0	230,055.1	(896.9)
татаас санхүүжилтын авлага	1,709.3	2,229.6	
Дүн	319,468.9	258,636.5	(60,832.4)

Эх сурвалж: Үенч сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 236347.3 мянган төгрөгийн дараах авлага байна.

Нийт авлагын дийлэнхийг сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлага эзэлж байгаа бөгөөд оны эхэнд 230952.0 мянган төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байсан ба тайлант 9000.0 мянган төгрөгийн зээл олгож, 10190.7 мянган төгрөгийн зээл, зээлийн хүү эргэн төлөгдөж, оны эцэст 230055.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Сум хөгжүүлэх сангаас 2016-2019 онуудад олгосон 67 зээлдэгчийн 102352.8 мянган төгрөгийн зээлийн авлага нь хэвийн төлөгдөж, 2011-2016 онуудад олгосон 19 иргэнтэй холбогдох 133944.5 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлага сангийн эргэцийг удаашруулж, хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна. Тухайн хугацаа хэтэрсэн 19 иргэнтэй холбогдох авлагыг 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр шүүх, хяналтын байгууллагад шилжүүлж ажилласан байна.

Хувь хүнээс авах 6292.2 мянган төгрөгийн авлага нь ажлаас гарсан ажилчидтай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Сумын ЗДТГ-т өмнөх онуудад ажлаас халагдсан албан хаагчидтай холбоотой насжилт өндөртэй авлагуудыг барагдуулан ажиллах шаардлагатай байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны үлдэгдэл 85779.9 мянган төгрөг буюу ямар ч өөрчлөлт гараагүй байна.

Хүснэгт 3: Урьдчилгаа дансны үлдэгдэл

мянган төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	84,000.0	84,000.0	0
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	1,779.9	1,779.9	0
Дүн			

Эх сурвалж: Үенч сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилж гарсан зардал дансанд бүртгэлтэй 84000.0 сая төгрөг нь малжуулах хөтөлбөртэй холбоотой малжуулах төсөлд хамрагдсан иргэд дараагийн малчиндаа малаар нь буцаан өгдөгтэй холбоотойгоор өөрчлөлт ороогүй байна. Бараа материал бэлтгэх урьдчилгаа дансанд бүртгэлтэй 1779.9 мянган төгрөг нь үйл ажиллагаа нь зогссон “Үенч-Эрчим хүч” ТӨААН-тэй холбоотой авлага байгаа ч барагдахгүй олон жил болсон байна.

3.5.4 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл 141529.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 133129.8 мянган төгрөг болж 8399.6 мянган төгрөгөөр байна.

Хүснэгт 4: Бараа материалын үлдэгдэл

мянган төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	26,911.8	26,911.8	-
Эм боох материал	8,024.2	18,234.7	10,210.5
Бичиг хэргийн материал	28.0	47.5	19.5
Аж ахуйн материал	6,124.7	6,164.0	39.3
Сэлбэг хэрэгсэл	12,116.2	6,199.2	(5,917.0)
Түлш, шатах тослох материал	20,175.8	8,317.8	(11,858.0)
Барилгын засварын материал	5,000.0		(5,000.0)

Хүнсний материал	10,986.7	11,566.4	579.7
Бусад хангамжийн материал	52,162.0	55,688.4	3,526.4
Мал амьтад			-
Дүн	141,529.4	133,129.8	(8,399.6)

Эх сурвалж: Үенч сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал 8399.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 290763.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч үнэ төлбөргүй 13552.8 мянган төгрөгийн бараа материал орлогод авч нийт 304316.9 мянган төгрөгөөр бараа материал нэмэгдэж 312716.1 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсантай холбоотой байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл 10538409.5 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 11393343.0 мянган төгрөг болж, 854933.5 мянган төгрөгөөр өссөн байна.~~

Хүснэгт 5: Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

мянган төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	7,225,412.2	7,988,543.1	763,130.9
Тээврийн хэсэгсэл	356,215.2	357,939.4	1,724.2
Машин тоног төхөөрөмж	2,124,576.3	2,156,689.2	32,112.9
Тавилга эд хогшил	401,908.3	448,049.0	46,140.7
Түүх соёлын дурсгалт зүйл	59.3	8,059.5	8,000.2
Дуусаагүй барилга байгууламж	126,913.3	126,913.3	-
Номын фонд	4,297.8	8,122.2	3,824.4
Бусад үндсэн хөрөнгө	129,880.6	129,880.8	0.2
Програм хангамж	3,628.5	3,628.5	-
Бусад биет бус хөрөнгө	165,518.0	165,518.0	-
Дүн	10,538,409.5	11,393,343.0	854,933.5

Эх сурвалж: Үенч сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 63540.6 мянган төгрөг, үнэ төлбөргүй хандив, хөрөнгө оруулалтаар авсан 842234.4 мянган төгрөгөөр нэмэгдэж Аймгийн ИТХ-ын тогтоолоор 33866.9 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан борлуулж акталсан 11975.8 мянган төгрөгөөр хөрөнгө хасагдаж тайлант оны элэгдлийн зардал 331128.1 мянган төгрөг байгаагаас шалтгаалжээ.

Аудитын илрүүлэлт:

-Дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй 129913.3 мянган төгрөгийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлэн ажиллаагүй төдийгүй хуулийн байгууллагад шалгагдаж байна.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. эхний үлдэгдэл 56150.3 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 22193.5 мянган төгрөг болж, 33956.8 мянган төгрөгөөр буурсан байна.~~

Хүснэгт 6: Өр төлбөрийн үлдэгдэл

мянган төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн				
Ажилчидтай холбогдсон өглөг	19,393.5	7,926.5	(11,467.0)	35.7

Бараа үйлчилгээний зардлын өглөг	10,389.9	10,389.9	-	46.8
Байгууллагад төлөх өглөг	26,366.9	3,877.1	(22,489.8)	17.5
Нийт дүн	56,150.3	22,193.5	(33,956.8)	100.0

Эх сурвалж: Үенч сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 22193.5 мянган төгрөгийн өр байгаагаас үйл ажиллагаа явуулахгүй байгаа “Үенч-Эрчим хүч” ОНӨААН-ийн 17029.2 мянган төгрөг байгаа нь үлдэгдэл өрийн 76.7 хувийг эзэлж байна. 5164.3 мянган төгрөгийн өр нь дараа тайлангийн хугацаанд бүрэн барагдах боломжтой өглөгүүд байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 7700845.9 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 8264438.6 мянган төгрөг болж 563592.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7: Засгийн газрын хувь оролцоо

мянган төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,985,615.3	4,990,615.3	5,000.0	60.4
Хуримтлагдсан үр дүн	706,330.9	1,264,923.6	558,592.7	15.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,008,899.7	2,008,899.7	-	24.3
Дүн	7,700,845.9	8,264,438.6	563,592.70	100

Тайлант онд Засгийн газрын сан данс 5000.0 мянган төгрөгөөр өссөн нь “Үенч Мөнх-Ундарга баялаг” ОНӨААТҮГ шинээр байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж эхэлсэнтэй холбоотойгоор газрын дахин үнэлгээтэй холбоотой байна.

Хуримтлагдсан үр дүн данс нь 558592.7 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх үеийн үр дансанд хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдлийг 8636.8 мянган төгрөгөөр хасаж залруулсан, тайлант оны үр 567229.6 мянган төгрөг байгаагаар холбоотой байна.

3.5.10 Орлогын данс

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 3769871.1 мянган төгрөг болж өмнөх оноос 150696.3 мянган төгрөгөөр буюу 3.8 хувиар буурсан байна.

Буурсан 150693.3 мянган төгрөгийн орлогоос материаллаг өөрчлөлт орсон торгуулийн орлого 37837.0 мянган төгрөг буюу 879.3 хувиар, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 24574069 мянган төгрөгөө буюу 50.9 хувиар, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого 226910.0 мянган төгрөгөөр буюу 12.7 хувиар, урсгал үйл ажиллагааны санхүүжилт 163521.9 мянган төгрөгөөр буюу 37.5 хувиар, нийгмийн даатгалын сангаас санхүүжих орлого 12223.2 мянган төгрөгөөр буюу 56 хувиар нэмэгдэж үндсэн үйл ажиллагааны орлого 662.0 мянган төгрөгөөр буюу 44.1 хувиар, туслах үйл ажиллагааны орлого 1745.6 мянган төгрөгөөр буюу 66.1 хувиар, нэмэлт санхүүжилтийн орлого 47014.2 мянган төгрөгөөр буюу 41.6 хувиар, орон нутгийн төсвөөс санхүүжигдэх орлого 587558.2 мянган төгрөгөөр 100 хувиар тус тус буурсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Орон нутгийн татварын орлогын биелэлтэд санхүүгийн албаны дарга хяналт тавиагүй хэдэн төгрөгийн орлого орохоос хэдэн төгрөгийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн талаарх мэдээллийг аудитад гаргаж өгөөгүй болно

3.5.11 Зардлын данс

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 3200041.0 мянган төгрөг болж өмнөх оноос 483086.0 мянган төгрөг буюу 13.1 хувиар буурсан байна.

Буурсан 483086.0 мянган төгрөгийн зардлаас материаллаг өөрчлөлт гарсан дараах зардлууд байна. Үүнд: Цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал 272737.9 мянган төгрөгөөр буюу 16.5 хувиар, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 32287.4 мянган төгрөгөөр буюу 15.9 хувиар тус тус нэмэгдэн байр ашиглахтай холбоотой тогтмол зардал 1043.0 мянган төгрөгөөр буюу 1 хувиар, хангамж бараа материалын зардал 157401.8 мянган төгрөг буюу 48.8 хувиар, нормативд зардал 54897.2 мянган төгрөгөөр буюу 31.7 хувиар, эд хогшил урсгал засварын зардал 7214.4 мянган төгрөгөөр буюу 62.4 хувиар, томилолтын зардал 6657.8 мянган төгрөгөөр буюу 57.7 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр 12073.5 мянган төгрөгөөр буюу 35.5 хувиар, бараа үйлчилгээний бусад зардал 30293.3 мянган төгрөгөөр буюу 6.3 хувиар урсгал шилжүүлэг 518530.4 мянган төгрөгөөр буюу 81.3 хувиар буурсан байна. Зардал буурах болсон шалтгаан нь Ковид-19 цар тахалтай холбоотойгоор сургууль, цэцэрлэг, соёлын төвийн үйл ажиллагааг хязгаарласантай холбоотой байна.

Зардлын данстай холбоотой 100662.3 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

- Сангийн сайдын 2018 оны 228 тоот тушаалын 3.11.3-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх” гэсэн заалтыг зөрчин ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлууд нь батлагдсан зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлгүй байхад ИТХ-аар оруулан батлуулсан. 3.1.4-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтад сум, дүүргийн төвөөс алслагдсан баг, хорооны иргэдийн хамгийн олон саналыг авч эрэмбэлэгдсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг заавал багтаах” гэсэн заалтыг зөрчин иргэдийн санал аваагүй арга хэмжээг ИТХ-аар оруулан батлуулж санхүүжүүлсэнтэй холбоотой 19106.9 мянган төгрөгийг санхүүжүүлжээ.
- ОНХС-гийн номын гэгээ хөтөлбөрөөс намрын налгар өдрүүд арга хэмжээнд 3000.0 сая төгрөгийг санхүүжүүлсэн.
- ОНХС-гаас ИТХ-ын хүндэтгэлийн хуралдаанд зориулж 1000.0 сая төгрөгийг санхүүжүүлсэн.
- ОНХС-гийн хөрөнгөөр эмэгтэйчүүдийн баяртай холбоотой зардлыг санхүүжүүлсэн.
- ОНХС-гийн хөрөнгөөр ЗДТГ-ын шатахуун болон сэлбэг хэрэгсэлд 2818.9 мянган төгрөгийг төлсөн.
- ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хурдан морины гарааны төхөөрөмж, стадионы засварын ажлууд дуусаагүй байхад авлагаар бүртгэхгүйгээр зардалд бүртгэсэн.
- Улиастайн амыг торлох ажилд 2 иргэнд нийт 13998.6 мянган төгрөгийг олгосон боловч одоог хүртэл тус иргэд нь ямар ч ажил хийгээгүй байхад зардалд бүртгэсэн.
- Бага хавтагт гүний худаг гаргах, гүний монтаж гаргах ажлын Алтайн хар сувд ХХК-тэй байгуулсан ч гүйцэтгэгч байгууллага нь өөр газарт худаг засварласан байгаатай холбоотой 5999.4 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.
- Сургуулийн тайлант оны элэгдлийн зардлыг 118918.3 мянган төгрөгөөр буруу бүртгэсэн
- И баримтаар баталгаажаагүй ажил гүйлгээг санхүүжүүлсэн.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Үенч сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай 2020 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн 12/02 дугаар тогтоолд Үенч сумын Төвлөрүүлэн захирагчийн тайлант онд 205350.8 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 145831.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 71 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт дугаар 8. Сумын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Орлогын ангилал	2020 оны		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
	205,350.8	145,831.9	59,518.9
Нийт орлого ба тусламжийн дүн	205,350.8	145,831.9	59,518.9
Татварын орлого	58,072.0	92,063.1	(33,991.1)
Орлогын албан татвар	13,651.0	32,648.1	(18,997.1)
Хувь хүний орлогын албан татвар	13,651.0	32,648.1	(18,997.1)
Үйл ажиллагааны орлого	1.0	1,601.3	(1,600.3)
Шууд бус орлого	13,650.0	31,046.8	(17,396.8)
Хөрөнгийн албан татвар	35,244.0	37,975.2	(2,731.2)
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	-	690.0	(690.0)
Бууны албан татвар	2,244.0	1,590.0	654.0
Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого	33,000.0	35,695.2	(2,695.2)
Бусад татвар, төлбөр, хураамж	9,177.0	21,439.8	(12,262.8)
Бусад нийтлэг төлбөр, хураамж	6,207.0	3,775.0	2,432.0
Улсын тэмдэгтийн хураамж	2,842.0	2,293.5	548.5
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	2,300.0	1,266.5	1,033.5
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1,065.0	215.0	850.0
Газрын төлбөр	-	11,314.9	(11,314.9)
Газрын төлбөр	-	11,314.9	(11,314.9)
Байгалийн нөөц ашигласны төлбөр	2,970.0	6,349.9	(3,379.9)
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	1,070.0	3,587.2	(2,517.2)
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	1,900.0	2,762.7	(862.7)
Татварын бус орлого	147,278.8	53,768.8	93,510.0
Нийтлэг татварын бус орлого	147,278.8	53,768.8	93,510.0

Хувьцааны ногдол ашиг	-	-	-
Торгуулийн орлого	5,000.0	42,140.2	(37,140.2)
Төсөвт байгууллагын өөрийн орлого	142,278.8	11,628.6	130,650.2

Эх сурвалж: Үенч сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт орлого 145831.9 мянган төгрөг буюу 59518.9 мянган төгрөгөөр тасалжээ. Орлого тасарсан шалтгаан нь хувь хүний орлогын албан татвар 18997.1, хөрөнгийн албан татварын орлого 2731.2, газрын төлбөрийн орлого 11314.9, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого 3379.9 мянган төгрөгөөр давуулан биелүүлж бусад татвар, төлбөр хураамжийн орлогыг 2432.0 мянган төгрөгөөр тасалжээ. Татварын орлого 33991.1 сая төгрөгөөр давуулан биелүүлэхэд Эрдэнэс таван толгойн хувьцааны ногдол ашгаас хувь хүний орлогын албан татварт 21634.6, газрын төлбөрийн хураамж 11314.9 мянган төгрөг гол нөлөө үзүүлжээ. Татварын бус орлого тасрах үндсэн шалтгаан нь СХС-гийн орлогыг 129383.2 мянган төгрөгөөр тасалснаас шалтгаалжээ.

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3114459.2 сая төгрөгөөр, нийт зарлагыг 3114459.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг сая 3114459.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрт зориулан 3114459.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2734429.1 мянган төгрөгийг урсгал зардалд, 240456.3 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, эргэж төлөгдөх зээлийн зардалд 139573.8 мянган төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 2009784.4 мянган төгрөгийг тусгай зориулалтын санхүүжилтээс, 722860.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 41367.2 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 198168.3 мянган төгрөгийг ОНХС-аас, 142278.8 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөж, санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Хүснэгт дугаар 9. Санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Үенч сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Д/д	Байгууллагын нэр	Нийт төлөвлөгөө			Гүйцэтгэл		Зөрүү	Тайлбар
		Санхүүжилт	Өөрийн орлого	нийт	Санхүүжилт	өөрийн орлого		
1	ЗДТГ	406,961.0	605.0	407,566.0	398,795.5	-	398,795.5	Батлагдсан төсвийг 3732.6 мянган төгрөгөөр дутуу авсан, 4432.9 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн.
2	ИТХ	60,230.6	-	60,230.6	57,693.9	-	57,693.9	Батлагдсан төсвийг 1335.0 мянган төгрөгөөр дутуу авсан, 1201.7 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн.
3	Сум хөгжүүлэх сан		139,573.8	139,573.8		10,190.6	10,190.6	Өөрийн орлогын төлөвөгөөг биелүүлэн ажиллаагүй
4	ОНХС	249,996.3		249,996.3	256,997.0	-	256,997.0	Давсан орлогоос санхүүжилт илүү авсан.
ОНБ-дын дүн		717,187.9	140,178.8	857,366.7	713,486.4	10,190.6	723,677.0	(142,617.7)
5	ЕБСургууль	1,253,465.4	600.0	1,254,065.4	1,213,268.3	600.0	1,213,868.3	40,197.1 Төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгө
6	Хүүхдийн цэцэрлэг	433,965.5	-	433,965.5	416,591.8	-	416,591.8	17,373.7 Батлагдсан төсвийг 5563.0 мянган төгрөгөөр дутуу, 11810.2 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн.
7	Эрүүл мэндийн төв	467,542.8	-	467,542.8	459,986.9		459,986.9	(7,555.9) ЭМД-аас 6917.8 мянган төгрөгийг дутуу авсан Орон нутгаас 637.6 мянган төгрөгийн дутуу авсан.
8	Соёлын төв	100,018.8	1,500.0	101,518.8	98,786.4	838.0	99,624.4	1,894.4 Орон нутгийн төсвөөс 2298.7 мянган төгрөгийн санхүүжилтийг илүү авч 4369.1 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн.
ТЗШ дүн		2,254,992.5	2,100.0	2,257,092.5	2,188,633.4	1,438.0	2,190,071.4	51,909.3
ОНӨААТҮГ дү		-	-	-	-	-	-	-
Нийт дүн		2,972,180.4	142,278.8	3,114,459.2	2,902,119.8	11,628.6	2,913,748.4	(90,708.4)

Эх үүсвэр: Үенч сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 11628.6 мянган төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 130650.2 сая төгрөгөөр тасарсан нь СХС-гийн зээлийн эргэн төлөлтөөс оруулах орлого, ЗДТГ өөрийн орлогын төлөвлөгөөг биелээгүйтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын 49 төсөл, арга хэмжээнд 240456.3 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 206626.4 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож үлдэгдэл 33829.9 мянган төгрөг нь ОНХС-гийн дансанд үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2913748.4 мянган төгрөг нь 93.5 хувьтай байгаа нь сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн төлөвлөгөө, ЗДТГ-ын өөрийн орлого тасарсан, Эрүүл мэндийн даатгалаас авах санхүүжилтийг дутуу авсантай холбоотой байна. ОНХС-гийн санхүүжилтийг давсан орлогоос 7000.7 сая төгрөгөөр илүү олгожээ.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 48027.6 мянган төгрөгийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засгийн газрын нөөц сан /Засаг даргын нөөц хөрөнгө/- 54731.3, дээд шатны төсвийн захирагчаас 4815.7 үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 5832.0 мянган төгрөг нийт 65379.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Хүснэгт дугаар 10. Нэмэлт санхүүжилт

/мянган төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	Нэмэлт төсөв			Тайлбар
		НДШ листийн орлого	Бусад орлого	Нийт	
1	ЗДТГ	-	58,728.0	58,728.0	ОНХС хөрөнгө оруулалт, хүн амын тооллогын зардал СХ

2	ИТХ	-	-	
3	ЕБСургууль	2,335.3	2,335.3	төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого, БСУГ -аас 500.0 төгрөг
4	Хүүхдийн цэцэрлэг	-	-	
5	ЭМТ	4,315.7	4,315.7	ЭМГ -аас эм бэлдмэлийн үнэ, сорьц тээврийн ажлын хөлс
6	Соёлын төв	-	-	
Нийт дүн		-	65,379.0	65,379.0

Эх үүсвэр: Үенч сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үүнээс бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээнд 3629.9 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 61749.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 151 мэдээллээс 135 мэдээллийг хугацаанд нь, 10 мэдээллийг хугацаа хоцроож, 6 мэдээллийг байршуулаагүй байна. ОНХС-гийн гүйцэтгэл, СХС-гийн бүх мэдээлэл, ОНХС, СХС-гийн санхүүгийн тайлан, ТТЗ-ийн аудитын тайлан, аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн ажлын тайлан, худалдан авах ажиллагааны тайланг мэдээлээгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 79641.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 3 төлбөрийн актаар 1477.1, 46743.3 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 31421.1 мянган төгрөгийн 10 алдаа зөрчилд зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт 95% хэрэгжсэн байна.

Хүснэгт 11 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	3	1477.1	3	1477.1	0	0	100%
Албан шаардлага	3	46743.3	3	46743.3	0	0	100%
Зөвлөмж	10	31421.1	9	26438.82	1	4982.28	84%
Нийт	16	79641.5	15	74659.22	4982.28	4982.28	95%

Өмнөх санхүүгийн тайлангаар өгөгдсөн 3 төлбөрийн актын 1477.1 мянган төгрөгийг бүрэн барагдуулсан, 3 албан шаардлагын 46743.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгаж ажиллаж 31421.1 мянган төгрөгийн 10 зөвлөмжөөс ЗДТГ-т өгөгдсөн насжилт өндөртэй ажилчидтай холбоотой 4982.3 мянган төгрөгийн авлагыг бууруулан ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 7 төсвийн байгууллага, 2 тусгай сан, нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 байгууллагыг аудитад хамруулан дүгнэлт гаргаж, 3 тайланг түүвэрт хамруулсан байна.

Хүснэгт №12. Аудитад хамрагдсан хэлбэр, аудитын дүгнэлт

Дүгнэлт

Байгууллагын ангилал, нэр	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Татгалзсан	Тайлбар
ЗДТГ	1			
ИТХ				түүвэрт хамрагдсан
Төсвийн шууд захирагч	Сургууль	1		Төсвийн төлөвлөлт гүйцэтгэл, зарцуулалт бодит бус зориулалт бусаар зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэл дутуу, тооллого тооцоо хийгээгүй, ойн хандиваар авсан бэлэн мөнгөний зарцуулалтын тооцоо хийгээгүй
	Цэцэрлэг	1		
	ЭМТ			итгэл үзүүлсэн
	Соёлын төв	1		итгэл үзүүлсэн
ОНТС	СХС			түүвэрт хамрагдсан
	ОНХС			түүвэрт хамрагдсан
ОӨААН	Үенч МУБ		1	санхүүгийн үйл ажиллагаанд өөрийн орлого, зарлагын төлөвлөгөөг батлуулаагүй, анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаагүй өөрийн байгууллагын нэрээр цэс нээж мэдээллээ байршуулаагүй
Дүн	2	3	1	

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”-2, “Хязгаарлалттай” 3, “Татгалзсан” 1 нийт 6 дүгнэлт гаргасан байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар илэрсэн алдаа, зөрчил:

Аудитаар нийт 176189.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 118918.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 19998.0 мянган төгрөгийн 1 алдаа зөрчилд төлбөрийн акт, 18166403 мянган төгрөгийн 2 алдаа зөрчилд зөрчлийг арилгах албан шаардлага, 19106.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайланд тайлант хугацааны элэгдлийн зардлыг 118918.3 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Улиастайн амыг торлох ажилд 2 иргэнд нийт 13998.6 мянган төгрөгийг олгосон боловч одоог хүртэл тус иргэд нь ямар ч ажил хийгээгүй байхад авлагаар бүртгээгүй, бага хавтагт гүний худаг гаргах, монтажлах ажлыг хийлгүүлсэн боловч гүйцэтгэгч аж ахуйн нэгж нь шинээр худаг гаргаагүй, өөр газарт хуучин худаг сэргээн засварласантай холбоотой 5999.4 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ” гэсэн заалтыг зөрчсөн, “Оршин байх”, “Тохиолдсон байх”, “Иж бүрэн байх”, “Эрх ба үүрэг”, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт бичих

Орон нутгийн хөгжлийн сангийн холбогдох журмыг зөрчин ИТХ-ийн төлөөлөгчдийг дэмжих үйл ажиллагаанд нь 1000.0 мянган төгрөг, Номын гэгээ хөтөлбөрөөс намрын налгар өдрүүд байр зохион байгуулахад 3000.0 мянган төгрөг, эмэгтэйчүүдийн баяртай холбоотой 858.0 мянган төгрөг, ЗДТГ-ын шатахуун, сэлбэгийн үнэд 2818.9 мянган төгрөг, олон нийтийн санал аваагүй 10489.5 мянган төгрөгийн ажлыг санхүүжүүлсэнтэй холбоотойгоор нийт 18166.4 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсантай холбоотойгоор Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6-д “орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн нь “Эрх ба үүрэг”, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

Шилэн дансны тухай хуулийг зөрчин шилэн дансны сайтад байршуулах ёстой ОНХС-гийн гүйцэтгэл, СХС-гийн бүх мэдээлэл, ОНХС, СХС-гийн санхүүгийн тайлан, ТТЗ-ийн аудитын тайлан, аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн ажлын тайлан, худалдан авах ажиллагааны тайланг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ.”, ЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан журмын холбогдох заалтуудын зөрчсөн нь “Иж бүрэн байх”, “Эрх ба үүрэг”, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

Төвлөрүүлсэн захирагчид 19106.9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 3 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн алдаа, зөрчил

Үенч сумын ТТЗ-ын нэгтгэлд хамрагдсан төсвийн шууд захирагчдын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1084871.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, 66244.9 мянган төгрөгийн алдааг залруулсан байна.

Залруулагдаагүй 1018626.2 мянган төгрөгийн алдаа зөрчлөөс 3564.3 мянган төгрөгийн 3 алдаа зөрчилд төлбөрийн акт, 1001526.9 мянган төгрөгийн 3 алдаа зөрчилд албан шаардлага, 13535.0 мянган төгрөгийн 8 алдаа зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна. Нийт алдаа зөрчил, шийдвэрлэлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 12. ТТЗ-ын нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн нийт алдаа зөрчил, шийдвэрлэлт /мянган.төгрөг/

№	Байгууллагын ангилал, нэр	нийт илэрсэн алдаа		Үүнээс залруулсан		Залруулаагүй		
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	
1	ЗДТГ	3	7,217.6	-	-	3	7,217.6	
2	ИТХ	-	-					
3	Төсвийн шууд захирагч	Сургууль	6	1,059,452.4	1	56,103.3	5	1,003,349.1
4		Цэцэрлэг	5	11,032.5	2.0	9,808.0	3	1,224.5
5		ЭМТ	-	-				
6		Соёлын төв	3	333.6	2.0	333.6	1.0	-
7	ОНТС	СХС	-	-				
8		ОНХС	-	-				
	ОНӨААТҮГ	Үенч МУБ	1	6,835.0			1	6,835.0
9	ТТЗ	Сумын нэгтгэл	-	-				

Дүн		18	1,084,871.1	5.0	66,244.9	13	1,018,626.2			
№	Байгууллагын ангилал, нэр	Залруулаагүй алдаа, зөрчил	Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
			тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн		
1		ЗДТГ	3	7,217.6	1	517.6	-	2	6,700.0	
2		ИТХ	0	-	-	-	-	-	-	
3	Төсвийн шууд захирагч	Сургууль	5	1,003,349.1	1	1,822.2	2	1,001,526.9	3	-
4		Цэцэрлэг	3	1,224.5	1	1,224.5	1	-	1	-
5		ЭМТ	0	-	-	-	-	-	-	
6		Соёлын төв	1	-	-	-	-	1	-	
7	ОНТС	СХС	0	-	-	-	-	-	-	
8		ОНХС	0	-	-	-	-	-	-	
	ОНӨААТҮГ	Үенч МУБ	1	6,835.0	-	-	-	1	6,835.0	
9		Сумын нэгтгэл	0	-	-	-	-	-	-	
	Дүн		13	1,018,626.2	3	3,564.3	3	1,001,526.9	8	13,535.0

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын гүйцэтгэл, чанартай холбоотой асуудлыг цаг хугацааны хувьд газар дээр нь очиж үзэж амжаагүй болно.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. ОНХС-гийн зарцуулалттай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Сумын ОНХС-гийн хөрөнгийг зарцуулахдаа иргэдийн санал аваагүй төсөл, хөтөлбөр, арга хэмжээг батлуулсан, техник эдийн засгийн үндэслэлгүй, зураг төсөвгүй ажлыг ИТХ-аар батлуулж санхүүжүүлжээ.
- 1.2. Эрсдэл: Сангийн хөрөнгийн үр өгөөж буурах, сангийн хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах
- 1.3. Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2018 оны 228 тоот тушаалын 3.11.3-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх”, 3.1.4-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтад сум, дүүргийн төвөөс алслагдсан баг, хорооны иргэдийн хамгийн олон саналыг авч эрэмбэлэгдсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг заавал багтаах” гэсэн заалтуудыг зөрчин иргэдийн санал аваагүй, ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлууд нь батлагдсан зураг төсөв,

техник эдийн засгийн үндэслэлгүй байхад арга хэмжээг ИТХ-аар оруулан батлуулж зарцуулдаг байдлыг таслан зогсоох

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2.1 . Орлогын бүртгэлтэй холбоотой асуудал

2.1.1. Илрүүлэлт: Тайлант онд тус байгууллага нь татварын болон татварын бус орлогыг дансанд орсон мөнгөн дүнгээр нь тайлагнаж санхүүгийн албаны дарга нь өөрийн албан тушаалын тодорхойлолтод заасан зорилтыг хэрэгжүүлээгүй байна.

2.1.2. Эрсдэл: Орлогын төлөвлөгөө тасрах, татварын орлого төлөгдөхгүй байх, татвараас зайлсхийх

2.1.3 Өгсөн зөвлөмж: Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 42 тоот тогтоолын 2-р хавсралтын 1 дүгээр зорилтын 6-д “Орлогын тогтвортой бааз суурьтай болох судалгаа, мэдээллийн сан бий болгох”, 2-р зорилтын 8-д “Орон нутгийн төсвийн орлогыг холбогдох байгууллага, албан тушаалтантай тооцоо нийлж...”, 3-р зорилтын хүрээнд “сумын төсвийн орлого бүрдүүлэхтэй холбоотойгоор татварын байцаагчийг шуурхай удирдлагаар хангах” гэсэн заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаж сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ААН, иргэдтэй тооцоо нийл орлогыг бүрэн оруулахад анхаарч ажиллах.

2.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрсөн

3.1 . Анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт: Сумын хэмжээнд худалдан авсан бараа бүтээгдэхүүн худалдан авахад гарсан зардлуудыг баримтжуулахдаа И баримтаар баталгаажуулаагүй байгаа нь борлуулагч талыг татвараас зайлсхийх боломжийг бий болгож байна.

3.1.2. Эрсдэл: Төсвийн зарцуулалтын хяналт сулрах, харилцагч байгууллага татвараас зайлсхийх

3.1.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Татварын ерөнхий хуулийн 28.5. “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж, худалдан авалтын ажил гүйлгээ бүрийг И баримтаар баталгаажуулахад анхаарч байгууллагын удирдлага, нягтлан бодогч, Төрийн сангийн төлөөлөгч нарыг удирдлагаар ханган ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 6 дугаар сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хавсралт

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Үенч сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан	Аудитын код:
--------	--------------	--	--------------

2020

ХОА-2021/12/СТА-ТТЗ

Шалгагдсан
байгууллагын нэр:

Үенч сумын Засаг дарга

Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	ОНХС-гаас мөнгөн хөрөнгө аваад одоо болтол ажлаа хийгээгүй	19998.0	Төлбөрийн акт	Засаг дарга, Санхүүгийн албаны дарга	Э.Уртнасан А.Энхзул
2	ОНХС-гаас Төсвийн тухай хуулийг зөрчин ажил гүйлгээг санхүүжүүлсэн.	18166,4	Албан шаардлага		
3	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаагүй		Албан шаардлага		
4	Залруулсан алдаа	118918,3	Залруулах		
5	ОНХС-гийн журмыг зөрчин ажил гүйлгээг санхүүжүүлсэн	19106,9	Зөвлөмж өгөх		
6	Санхүүгийн албаны дарга албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй	0	Зөвлөмж өгөх		
7	Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг санхүүжүүлсэн	0	Зөвлөмж өгөх		
	Дүн	176189.6			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР